

МОНОС ХҮНС ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 18 өдөр

№ 24/15

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
хороодын дарга, гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, Монос Хүнс ХК-ийн дүрмийн 7.15, 7.16, 7.17, 7.18, 7.19 дүгээр заалтууд, 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосонтой холбоотой ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - 1.1. Аудит, эрсдэлийн хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Золжаргал, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Улаанхүү, ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Сарандаваа, ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Цэцэгбадам, ТУЗ-ийн ердийн гишүүн Х.Солонго нарыг,
 - 1.2. Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн ердийн гишүүн Х.Ананд, ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Сарандаваа, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлт-Од нарыг,
 - 1.3. Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Энхжаргал, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Улаанхүү, ТУЗ-ийн ердийн гишүүн Х.Ананд нарыг,
 - 1.4. Стратеги, бизнес хөгжлийн хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлт-Од, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Энхжаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Золжаргал, ТУЗ-ийн ердийн гишүүн Х.Солонго, ТУЗ-ийн ердийн гишүүн А.Отгондарь нарыг,
2. Ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой мөрдвөл зохих хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон баримтлаж, хуулийн хүрээнд ажиллахыг шинээр томилогдсон хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг зохих журмын дагуу цалинжуулахыг Монос хүнс ХК-ийн Санхүү хариуцсан захирал /Ц.Дэлгэрмаа/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА Х.АНАНД

